



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

“Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жил” –ийн
нээлтийн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Нийслэлээс 2026 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил”, дүүргээс “Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан, зорилтот жилийн төлөвлөгөөг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор нээлтийн арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр чанар, үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Нээлтийн арга хэмжээний хөтөлбөрийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулагдах 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Нээлтийн арга хэмжээнд дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 сарын 27-ны өдрийн 16 дугаар
нэгдүгээр захирамжийн хавсралт

“ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН
НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Зорилго: Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жилийн хүрээнд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэд, олон нийтэд сурталчлан таниулахад оршино.

Зохион байгуулагч: Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар


Хугацаа: 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 09.00 цагт

Зохион байгуулагдах газар: Дүүргийн 1-р хороо Соёлын ордон

Оролцогч: Багахангай дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагч, иргэд

№	Хөтөлбөрийн дараалал	Цаг, мин	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх
1.	Хөтлөгч үг хэлэх /эхлэх/	09.00-09.03	Хөтлөгч	
2.	Төрийн дуулал эгшиглүүлэх	09.03-09.05	Мэргэжилтэн	Соёлын ордон
3.	Засаг дарга нээж үг хэлэх	09.05-09.10	Засаг дарга А.Сүхболд	М.Батсайхан
4.	Хэлэлцүүлэг-1 (Үйлдвэрлэлийн чиглэлээр)	09.10-09.40	Модератор	Панелист Оролцогчид
5.	Урлагийн номер (2 дуучин)	09.40-09.50	Соёлын ордон	Нийгмийн хөгжлийн хэлтэс
6.	Хэлэлцүүлэг-2 (Худалдаа үйлчилгээний чиглэлээр)	09.50-10.20	Модератор	Панелист Оролцогчид
7.	Хэлэлцүүлэгтэй холбоотой санал хүсэлт	10.20-10.35	Модератор	Оролцогчид
8.	ИТХ-ын дарга мэндчилгээ хүргэнэ	10.35-10.40	ИТХ-ын дарга Ф.Мөнхгэрэл	Ц.Мөнхтулга
9.	Хөтлөгч үг хэлэх /хаах/	10.40-10.45	Хөтлөгч	

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны... сарын... -ны өдрийн... дугаар
хоёрдугаар захирамжийн хавсралт



“ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН
НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	“Бидний мэдэх Битлз” үзэсгэлэн	ш	1	1,000,000	1,000,000
2	Дуучин		1	1,000,000	1,000,000
Нийт дүн					2,000,000